Хөөмийн урлагийн үүсэл, тархацын талаарх мэдээллийг мөшгисөн дүн

Ц.Рэнцэндорж[1], П.Ганчимэг[1], Л.Бямбасүрэн[2], Б.Дагданбазар[4], С.Энэбиш[3], Б.Журамт[3], Д.Нямдорж[3]

[1]АШУҮИС-ЧХХ тэнхим
[2]УНТЭ-ЧХХ тасаг
[3]АШУҮИС-Анатомийн тэнхим
[4]Ач анагаах ухааны сургуль
Email: rentsendorj@mnums.edu.mn, Утас: 976-11-321371

Түлхүүр үг:
Хөөмийн урлаг
Үүсэл
Тархац
Хэвлэлийн тойм

Товч утга:
Үндэслэл: Монгол туургатны бий болгож, хөгжүүлж, уламжлуулж ирсэн хөөмийн урлагийг түүх, соёл урлаг, газар зүй, физик, авиа зүй зэрэг шинжлэх ухааны салбар бүрээс сонирхон судлах эрдэмтэн судлаачдын тоо нэмэгдэж үүний хэрээр тэдгээр судлаачдын сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны ажлын явц, үр дүнтэй танилцаж, цаашдын судалгааны ажлын чиг хандлагыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. **Зорилго:** Хөөмийн урлагийн үүсэл, тархацын талаар хийгдсэн судалгааны ажлын хэвлэлийн тоймыг цуглуулан дүн шинжилгээ хийх. **Зорилт:** 1.Хөөмийн үүсэл тархацын талаарх судалгааны ажил, нэг сэдэвт бүтээлүүдтэй танилцаж хэвлэлийн тоймыг цуглуулах. 2.Хэвлэлийн тоймтой танилцан дүн шижилгээ хийх. 3.Цаашид хийгдэх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох. **Арга аргачлал:** Монгол хөөмийн урлагийн талаар үндэсний номын сан, СУИС, МУБИС-ийн номын сангуудад хадгалагдаж байгаа ном, эрдэм шинжилгээний сэтгүүл, нэг сэдэвт бүтээлүүд болон олон улсын эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сангуудаас авсан эрдэм шинжилгээний ажлуудад эх зохиол судлалын аргаар танилцаж, дүгнэлт хийв. **Дүгнэлт:** Хөөмийн урлагийг түүх, соёл урлаг, газар зүй, авиа зүйн талаас судалсан эрдэм шинжилгээний ажил цөөнгүй байгаа боловч анатоми бүтэц, үйлзүйтэй холбон судалсан эрдэм шинжилгээний ажил хомс байгаа нь цаашид энэ чиглэлээр хийгдэх судалгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Үндэслэл: Монгол туургатны бий болгож, хөгжүүлж, уламжлуулж ирсэн хөөмийн урлагийг түүх, соёл урлаг, газар зүй, физик, авиа зүй зэрэг шинжлэх ухааны салбар бүрээс сонирхон судлах эрдэмтэн судлаачдын тоо нэмэгдэж үүний хэрээр тэдгээр судлаачдын сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны ажлын явц, үр дүнтэй танилцаж, цаашдын судалгааны ажлын чиг хандлагыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зорилго: Хөөмийн урлагийн үүсэл, тархацын талаар хийгдсэн судалгааны ажлын хэвлэлийн тоймыг цуглуулан дүн шинжилгээ хийх

Зорилт:
1. Хөөмийн үүсэл тархацын талаарх судалгааны ажил, нэг сэдэвт бүтээлүүдтэй танилцаж хэвлэлийн тоймыг цуглуулах
2. Хэвлэлийн тоймтой танилцан дүн шижилгээ хийх
3. Цаашид хийгдэх судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох

Арга аргачлал: Монгол хөөмийн урлагийн талаар үндэсний номын сан, СУИС, МУБИС-ийн номын сангуудад хадгалагдаж байгаа ном, эрдэм шинжилгээний сэтгүүл, нэг сэдэвт бүтээлүүд болон олон улсын эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сангуудаас авсан эрдэм шинжилгээний ажлуудад эх зохиол судлалын аргаар танилцаж, дүгнэлт хийв.

Үр дүн: Хөөмий нь хөгжмийн зэмсэг үл хэрэглэн нэгэн зэрэг хоёр ба түүнээс дээш, олон давхар эгшиг, аялгуу болох хархираа хөөмий буюу цээжний гүнээс түрэн гарах авиа, исгэрээ буюу амны хөндийнөөс гарах авиа, нармай хөөмий буюу хамраар гаргах авиа, шахай хөөмий буюу хоолой шахаж гүнээс гарах авиа зэрэг олон төрлийн дуугаралтыг үүсгэдэг язгуур урлагийн нэгэн төрөл юм.[1,2] Монгол хөөмийн 4 төрөл байдаг ба Үүнд:

Хархираа – Цээжний гүнээс түрэн гарах авиа
Исгэрээ – Амны хөндийнөөс гарах авиа
Нармай – Хамраас гарах авиа
Шахай – Хоолой шахаж гүнээс гарах авиа

зэрэг тус тус хамаарагдах бөгөөд уруулын, тагнайн, хамрын, багалзуурын, хоолойн, цээжний, хэвлийн түрлэгт, хосмолжин хөөмий гэж ангилах нь ч бий.[3]

Хөөмийн үүсэл, тархац, бүс нутгийн онцлогийн чиглэлээр хийсэн судалгааны тойм: Хөөмий нь эрт цагаас эхлэн өнөөг хүртэл Монгол түмэнд үеэс үед уламжлагдан ирсэн язгуур урлагийн үнэт өв болохыг ЮНЕСКО-оос батламжилж, хүн төрөлхтний биет бус соёлын өвийн жагсаалтад 2010 онд бүртгэгдсэн байна.[4]

Хөөмийн үүссэн цаг хугацаа нь тодорхойгүй боловч хясаа, цохио хавцал бүхий уул нурууд энд урсах гол, түүний харгиа, хүрхрээ зэрэг элбэгтэй газар нутгаар тархсан байна. Үүнтэй холбоотой ардын домог яриа цөөнгүй байгаа нь хөөмийн үүслийн нэгэн нотолгоо байж болох юм.

Ардын аман яриа: Эртнээс хүн ан авлахдаа буга мэт урамдаж, чоно мэт улин дуурияж хөөмий үүсчээ.

Хөөмий үүссэн домог №1: Эрт балар цагт нэгэн өнчин хоцорсон бяцхан хүү олон өнгөөр цуурайтах өндөр уулын хавцлын бэлд гурван жил ганцаар амьдарчээ. Хүчтэй салхи салхилахад хавцлын дунд цуурай үүсдэг байв. Хүү ганцаар амьдрахдаа зөвхөн байгаль дэлхийд өөрийгөө илэрхийлдэг байсан бөгөөд байгаль дэлхий ч хүүд тусалжээ. Нэгэн өдөр хүү хавцлаас гарах дуу авиаг дууриалган дуугарчээ. Түүний энэ дуурайн дуугарсныг салхи хүмүүст хүргэснээс хойш энэ дууг “хөөмий” гэж нэрлэсэн байна.

Хөөмий үүссэн домог №2: Хятадын эртний нэгэн сурвалж бичигт Тайшийн нэгдүгээр он буюу аргын тооллын 92 он Чинус (чоно) овогт буюу өөрсдийгөө чононоос үүсэлтэй хэмээн үздэг цөөн хэдэн зэрлэгүүд давуу хүчтэй дайсны хүчтэй тулгараад араатан мэт аймшигтай баргил бүдүүн дуугарцгаана. Дайснаа айлгаж явуулсны дараа гал түлж тойрон бүжиглэхдээ мөнөөх хачирхалтай авиагаа гаргах нь аймшигтай гэжээ.

Хөөмий үүссэн домог №3: Нэгэн эр Алтайн ууланд зугатаж яваад Ээвэн хэмээх голын дэргэд хоноглохдоо чимээг дуурайх гэсээр хөөмий үүсэв.

Монгол хөөмийн урлаг нь үүсч хөгжсөн Монгол улс төдийгүй дэлхийн олон улс үндэстнүүдийн дунд ч өөрийн онцгой гайхамшигт дуугаралтаар өндөр түвшинд үнэлэгдэн, дээд хэмжээнд дэвшилттэйгээр хөгжин яваа язгуур урлагийн нэгэн төрөл юм.[5] Хөөмийн урлаг үүсэх, хөгжих, түгэн дэлгэрэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл бол оршин байгаа байгаль газар зүй, ан амьтан, жигүүртэн шувууд юм.[6]

Хөөмийн урлаг нь өмнөд Сибирь, Саяны уулс, Баруун Алтайн уулсын орчимд буюу өнөө цагийн Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай зэрэг аймгуудын нутагт үүсч энэ хэсэгт амьдрах халх, дөрвөд, баяд, буриад, үзэмчин зэрэг хорь гаруй ястнуудын дунд түгэн анх үүсч, нүүдэлчин Монголчуудын амьдралын хэв маягаар улбаалан Төв Ази, Зүүн Азийн зарим хэсэг зэрэг мөнх цаст өндөр уулын бүст амьдрах түмэн буюу Монгол, Орос (Хакассийн бүгд найрамдах улс, Тува, Алтайн бүгд найрамдах улс, Буриад улс), Хятад (Өвөр Монголын өөртөө засах орон, Түвдийн автономит мужууд, Шиньжян-Уйгурын өөртөө засах орон) зэрэгт дэлгэрч тархсан гэж үздэг байна.[7]

Хөөмий (, , Хöömii) нь язгуур Монгол үг бөгөөд үгчилбэл тагнайн уг гэх ба Монгол хэлэнд үндсэн хоёр утгаар хэрэглэгдэнэ. Үүнд: 1.Хөөмий-залгиурын амсар буюу хэлний уг, хүүхэн хэл, тагнайн гүйлсэн булчирхайгаар хязгаарлагдсан цагариг: хөөмийн гүн (тагнайн угт хөнтрөн ургасан мах, хүүхэн хэл); 2.Хөөмий-Нарийн үст амьтны өехийн дагуу арьсны өнгө төсөөтэй хэсэг газар; гэж тус тус тайлбарлагддаг байна.[8] Харин Алтай, Хакасс, Тува зэрэгт хөөмийг Хөөмэй (khöömei), Кай (Kai), Хай (Khai) гэж дууддаг байна.

Ховд аймаг: Ховд аймаг нь Алтайн нуруу Монгол Алтайн их уулсын дунд оршиж баруун хойт талаараа Баян-Өлгий аймагтай, хойт талаараа Увс аймагтай, зүүн талаараа Завхан, Говь-Алтай, аймагтай, өмнө талаараа Хятад улсын Шиньжан-Уйгарын өөртөө засах орны газар нутагтай тус тус хиллэн оршдог бөгөөд Чандмань уулын аймаг нэртэй байж бүрэлдэхүүнд нь 8 хошуу, 41 сум хамаарагдаж байгаад 1931 онд Увс, Ховд хэмээн хоёр аймаг болгоход 13 сумтайгаар байгуулагдажээ. Ховд аймаг олон угсаатан, ястангуудтай ба бүгд өөрсдийн уламжлалт суурин газар, түүний хэв маяг, уламжлалт хувцас зэрэг соёлын ялгаанууд, мөн уран зохиол, урлаг, дуу хөгжмийн уламжлалуудаа хадгалан иржээ. Өдгөө Ховд аймаг нь захчин (Алтай, Мөст, Зэрэг, Манхан, Үенч), Урианхай (Мөнххайрхан, Дуут), Өөлд (Эрдэнбүрэн) Халх (Чандмань, Дарви, Цэцэг, Буянт), Торгууд (Булган) зэрэг олон ястан бүхий 17 сумтайгаас халх сумдын нэг болох Чандмань сум нь **“Хөөмийн урлагийн өлгий нутаг”** хэмээн дотоодын төдийгүй, гадаадын олон тооны судалгаа, ном сурах бичигт тэмдэглэдсэн байна. Түүнчлэн Булган сумын Торгууд, Урианхай ястангуудад ч хөөмийн урлагийн эх өлгийн нэг гэж тэмдэглэсэн нь ч байна.[9]

Судлаач Pegg C (1992) нарын Англий угсаатны зүй сэтгүүлд нийтлүүлсэн Монгол хөөмийн үзэл баримтлал хэмээх эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээлдээ Алтайн уулсын зүүн өвөр хэсэгт баруун Монголчууд (Ойрдууд) ирж сууршихаас өмнө нутгийн түмний шүтээн нь “Ээв” хэмээх гол байсан гээд энэ голын харгиа, хүрхрээний чимээ зэргээс хөөмийн анх үүссэн тухай домог яриа байдгийг тэмдэглэсэн байна. Түүнчлэн Урианхайчуудын дунд ч энэ голын тухай “Ээв голын уснаас Элэхээс өмнө хүртэхсэн” гэх хэлц байдгийг тэмдэглэн үлдээсэн байна.[10]

Өдгөө уг голын байршил тодорхойгүй маргаантай ба зарим судлаачдын үзэж байгаагаар БНХАУ-ын Шиньжан-Уйгарын өөртөө засах орны Тарвагатай аймгийн Дөрвөлжин сумын нутаг орчимд байна гэсэн бол (Б.Мөнхбадрал нарын хөөмийч Ц.Цэрэндаваатай хийсэн ярилцлага 2007.05.06) судлаач Ж.Бадраа нар Монгол улсын Хөвсгөл аймгийн нутагт (Ж.Бадраа. Монгол ардын хөгжим. 1999) харин Б.Мөнхбадрал нарынхаар уг гол Ховд аймгийн Чандмань суманд байдаг ба Хар Ус нуур болон Алтайн өндөрлөг уулсын шувуудын жиргээг дагаж Алтайн шингэн хөөмэй болон багалзуурын нарийн хөөмэй үүссэн гэж тэмдэглэсэн байна.[11] “Ээвэн голын урсгал” хэмээх дууг лимбэчин н.Түвшээгийн лимбэдсэнээр (1964) болон П.Цэрэндоржийн дуулснаар (1988) Монголын Үндэсний олон нийтийн радиогийн архивт хадгалагдаж байгаа нь энэхүү гол үнэхээр байсныг нотлох аман соёлын нэг болж байна.[12,13]

Ховд аймгийн Чандмань сум нь далайн түвшнээс дээш 1132.3-3796 м өргөгдсөн бүх талаараа

уул, усаар хүрээлэгдсэн хангай, говь хосолсон байгалийн өвөрмөц тогтоц нутаг юм. Чандмань сумын баруун талд Хар-Ус нуур, Зүүн Жаргалантын нуруу, Хүрэмтийн нуруу, зүүн талд нь Дөргөн, Хар нуур оршиж уг хоёр нуур Чоно-Харайхын голоор хоорондоо холбогддог төдийгүй Хар-Ус нуурын илүүдэл ус Чоно Харайхын голоор дамжин Хар нуур руу цутгадаг бол өмнө талд нь элсэн манхан оршдог байна. Нутгийн ахмад хөөмийчдийн хууч, газар нутгийнхаа онцлогийн талаар дурьдсан яриа зэргийг тэмдэглэн сийрүүлсэн гадаадын болон дотоодын судлаачдын бүтээлд Зүүн Жаргалантын нуруу, хадан хавцлын завсраар үлээх салхи нь хөөмий лугаа адил өвөрмөц дуу чимээ, цуурай үүсгэх ба энэ нь өглөө оройд ч ялгаатай төдийгүй бороо орох чимээ ч уулын ам бүрээс ялгаатай сонсогддог гэжээ.[14] (Нутгийн уугуул, хөөмийч Д.Цэрэндаваатай судлаач Pegg.C нарын хийсэн ярилцлага. Зураг 1,2)



Зураг 1. Хөөмийч Д.Цэрэндаваа. Жаргалант уулын хүрхрээний өмнө. Хөөмийн урлагийн их мастер баримтат киноны зураг авалтын үеэр (Ховд аймаг Чандмань сум, зургийг J. Curtet, 2010)

Түүнчлэн уг нутагт байх зарим төрлийн шувуудын нэг болох усны бух шувуу нь үүрлэн буй газраасаа урамдах лугаа адил дуугардаг ба энэ нь хөөмийтэй нэн төстэй төдийгүй саахалтын газраас сонсогддог. Түүнчлэн Хойлог шувуу нуур, хавцлын дээгүүр дэвэн нисэхэд ч хөөмийтэй ижил чимээ дуугардаг гэж нутгийн уугуул, хөөмийч Сэнгэдоржийн ярицлагад дурьджээ. (Б.Нанжид нар Ховд аймгийн театрт хийсэн ярилцлага. 1989.07.13)



Зураг 2. Ховд аймаг. Чандмань сум. Жаргалант уулын ам. (J. Curtet, 2010)

Увс аймаг: Увс аймаг нь баруун талаараа Баян-Өлгий аймаг, өмнө талаараа Ховд аймаг, зүүн талаараа Завхан аймаг, хойт талаараа ОХУ-ын Тува улстай тус тус хиллэн оршдог бөгөөд Чандмань уулын аймгаас 28 сумтайгаар өрх тусгаарласан байна. Тус аймагт Баяд, Дөрвөд, Хотон зэрэг ястангууд зонхилон оршиж хөөмийн урлаг нь Баяд түмний дунд хамгийн түгээмлээр тархсан тухай баримт цөөнгүй байна. Нутаг орны байгаль цаг уур, газарзүйн онцлогоос шалтгаалан хөөмийн өнгө аяс өөр өөрийн онцлогтой ба Увс, Тувагийн нутгаар хархираа хөөмий илүү хөгжсөн гэж судлаач Ж.Долгорсүрэн нарын бүтээлд дурьдсан байна.[15]

Баян-Өлгий аймаг: Баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шиньжан-Уйгарын Өөртөө засах оронтой, хойт талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улстай, зүүн талаараа Увс аймагтай, зүүн ба урд талаараа Ховд аймагтай тус тус хиллэн оршдог. Тус аймагт Казак, Тува, Урианхай ястан зонхилон орших ба хөөмийн урлаг нь Цэнгэл сумаас ОХУ-ын Тагна-Тува-руу түгэн тархсан гэж Curtet J (2013) нар бүтээлдээ дурьдсан байна.[16] Мөн Говь-Алтай, Завхан аймгийн Баянтэс, Баянхайрхан, Алдархаан, Хөвсгөл аймгийн цаатан урайнхайчууд зэрэг нүүдэлчин түмний дунд уламжилсаар ирж хөгжингүй хэлбэрээр тархсан байна. (Зураг 3)



Зураг 3. Азийн орнуудад хөөмийн урлагийн тархсан байдал

Түүнчлэн Өмнөд Африкийн Чоса (Xhosa) омгийнхон Umngqokolo ngomqangi хэмээх хөөмий төст өвөрмөц аялгуу хоолойн шахалтаар дуугаргадаг байна. Энэ нь Xhosa омгийн хөвгүүд Umqangi хэмээх том биетэй цохыг үзүүрт саваа, өргөс зэргээр хатгах үед их чимээ бүхий дуу авиа гаргаснаас үүдэлтэй гэж судлаачид тэмдэглэсэн байна.[17,18]

Мөн хөөмий төст аялгуу буюу хоёр ба түүнээс дээш, олон давхар эгшиг, аялгуу гаргадаг соёл уламжлал бүхий зарим улс орон дэлхийд тархан байгаагаас Башкирын Бүгд Найрамдах Улс (Башкирстан), БНХАУ-ийн Төвдийн өөртөө засах орны Буддын шашны лам хуврагууд лам нар ёслолын ном хурах үеэр болон Канадын хойд хэсгийн Инуит (Эскимос) “katajjaq өөрөөр Iglulik буюу Хоолойн тоглоом” (vocal game)-ийн үеэр тус тус гаргадаг байна. “Хоолойн тоглоом” гэх язгуур урлагийн энэ өвөрмөц төрөл Япон улсын Хонсью

арлын хойт хэсгээр Хоккайдод амьдардаг нутгийн уугуул иргэд болох Айну (Ainu-蝦夷-アィヌ) омгийнхны дунд rekkukara (rekuhkara) нэрээр тохиолддог төдийгүй үүнтэй хил залгаа Оросын Сахалин, Курилын арлууд, Хабаровскийн хязгаар, Камчатка хойг зэрэгт ч түгсэн байдаг байна.[19-21] (Зураг 4)



Зураг 4. Хөөмий төст аялгуу буюу хоёр ба түүнээс дээш, олон давхар эгшиг, аялгуу гаргадаг соёл уламжлал бүхий зарим улс орон тэдгээрийн төлөөлөл

Тува: Өнөө цагт хөөмийн урлагийг Монгол болон Тува хөөмий гэж хоёр ангилдаг. Тува нь уламжлалт Монгол тодорхойлолтоор Урианхай, бүр тодруулбал Тагны Урианхайчууд гарал нэгтэй гэж түүхчид үздэг ба Сибирийн өмнөд хэсэгт орших Саян-Алтайн нутаг дахь Соёны нуруугаар буюу 80% нь ой тайгат уулархаг газар, үлдэх хувь нь уулсын завсрын хээр, голуудын хөндий голлон нутагладаг ястан юм. Тагна Урианхай, Соён уранхай гэж 2 хуваагддаг бөгөөд тэд нь Хар сүлд болон Цагаан сүлдээр бас ялгагддаг байна. Одоогийн ОХУ-д амьдарч байгаа Тувачууд Хиргис болон Сахачуудтай (Якутууд) холилдон бий болсон ба Монгол улсын Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Увс, Ховд аймагт цөөн тоогоор оршин суудаг.

Тува нь 1921-1944 онд Танну Тува, 1961-1991 онд Тувагийн Автономит Бүгд Найрамдах Социалист Улс, 1991 оноос Тувагийн бүгд найрамдах улс болон нийгэм, улс төрийн өөрчлөлт явагдсан нь хөөмийн урлагийн хөгжилд ч шинэчлэл хийхэд хүргэсэн гэж судлаачид тэмдэглэсэн байна.[22,23] Тувагийн хөөмий нь Алтай, Буряд, Монголын хөөмийгөөс олон янзын хэлбэрээр ялгардаг. Тува улсын хөөмий нь Хойд Сибирийн Тувачуудын дунд тархсан. Тувачуудын хөөмий нь мөн адил баялаг түүхтэй, өөрийн гэсэн онцлогтой боловч ихэнхидээ хөрш зэргэлдээ орших Монголын хөөмийн урлагтай холбоотой, түүний нэгэн төрөл нь байдаг байна.

Тува хөөмийн арга барил нь тухайн нутгийн уугуул нутгийн бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой буюу "нүүдэлчин" шинж чанар бүхий түүхэн хэлбэртэй байжээ. Тувагийн янз бүрийн хөөмийний үүсэл гарлын талаар ард түмний дунд олон домог байдаг. Балар эрт цагт тэмээ хариулдаг хүмүүс хархираа хэлбэрээр хөөмийлдөг байжээ. Ботго нь үхсэн ингэ хархираатай төстэй дуу авиа гаргаж, тэшидэг байна. Ингэж ингэ буйлахыг дууриаж дуугарснаас хархираа хөөмий үүсчээ гэсэн байдаг бол өөр нэгэн үлгэрт “Боролдой өвгөн гэрийн хаалгаар өнгийхөд алтан гүнж байхыг харжээ. Гүнжийн үсийг зургаан бүсгүй алт-мөнгөн утсаар гөрж, гурван бүсгүй гоёл чимэглэлийг нь зүүж, зургаан залуу хархираа, хөөмий, сыгытыг хөөмийлж байжээ (Бөх шар морьтой Боролдой өвгөний үлгэр).[24]

Тува Хөөмийн онцлог нь акустикийн хувьд хамгийн доод үелзлийн шүнгэнэх дуу авиатай холбоотой ба Монгол хөөмийнээс ялгаатай нь Монгол хөөмийг бодоход шингэн, хүч султай, тэр болгон ая дан оруулж болдоггүй буюу бүүвэйн дуу хэлбэрийн шүлгээр хөөмийлөх боломжтой. Тува хөөмийн төрөлд Хархираа, Хөөмий, Сыгыт, Эзегилээр, Борбаннадыр зэрэг хөөмийн үндсэн таван хэлбэр байдаг. Мөн хөөмийний думчуктар (шинэ), хоректээр (цээжнээсээ дуулах), хову каргыыраазы (талын хархираа) зэрэг хэд хэдэн төрөл байдаг ажээ. Хархираа гэсэн нэр томъёо нь хархирах буюу хяхтнах дуутай төстэй дуу авиаг илтгэж байгаа юм. Сыгыт нэр томъёо нь гаслан уйлах гэсэн утгатай юм. Хөөмийн нөгөө хэлбэр эзенгилээр дөрөө буюу эзенги гэсэн үгнээс үүссэн. Энэ хөөмий нь хөгжмийн онцлог, үндсэн санааг маш сайн илтгэдэг. Мориор давхих үед эмээлд тохсон мөнгөн хазаар дөрөөтэй харшилдаж, тодорхой хэмнэлтэй дуу авиа гаргадаг байна. Ийм дуу авиа гаргахын тулд морьтон эмээлдээ тодорхой байдлаар сууж, морио жороолуулах хэрэгтэй юм. Эзенгилээр хөөмий энэ дуу авиаг дууриалгаж дуугарахаас үүсчээ. Борбаннадыг хөөмий нь бөөрөнхий зүйл өнхөрүүлэх гэсэн Тува хэлний “Борбаннат” үйл үгээс үүссэн. Энэ нь хэмнэл бүхий хөөмий юм. [25,26]

Монгол орон дахь хөөмийн урлагийн хөгжил, өнөөгийн чиг хандлага: Хөөмийн урлаг Монгол оронд анх үүсэн бий болсон цагаас өнөөг хүртэл хөгжлийн олон замыг туулж ирсэн ба албан бус мэдээгээр Хүннү нараас үүсэл, гаралтай гэх боловч нийтийн хүртээл болсон үеийг зарим судлаач нар 1930-1940 он орчимд гэж үздэг. Үүний дараа хөөмийн урлагт нэгэн дэвшил гарсан нь 1954 онд Ховд аймгийн соёл урлагийн арав хоногийн үеэр Чандмань сумын ардын авъяастан н.Цэдээ “Алтай ханы магтаал”-ыг найрал дуутайгаар анх удаа хөөмийлсөн нь энэ урлагт үсрэлт болсон гэж үздэг. Эндээс улбаалан хөөмийлэх аялгуу уртассан ба ардын дууны хэмнэл аялгууг даган хэмнэл

хөдөлгөөн нь баяжиж тайвуухан бөгөөд цэвэрхэн хөөмийлөх боломж нэмэгдсэн байна. Түүнчлэн 1983 онд Ховд аймгийн Чандмань сумын 8 жилийн дунд сургуульд Монголын анхны Хүүхдийн хөөмийн чуулга “Жаргалантын цуурай” нэртэйгээр нээгдэн ажиллаж байсан баримт байна. (Зураг 5)



Зураг 5. “Жаргалантын цуурай” Хүүхдийн хөөмийн чуулгын гарын авлага

Өдгөө судлаач Ч.Бат-Оюун “Монгол хөөмийн урлагийн зарим асуудал”, Ш.Энхжаргал “Монгол хөөмийн төрөл зүйлийн онцлог”, Ж.Мэндбаяр “Хөөмийн тархац бүс нутгийн онцлог”, Л.Хэрлэн “Монгол хөөмийн утга холбогдол”, С.Загд-Очир “Хөөмийчний уран чадварын зарим асуудал”, Ц.Цогтгэрэл “Хөөмийлэх арга барилын асуудалд”, Б.Одсүрэн “Монгол хөөмийн мэргэжлийн сургалтын арга барилын онцлог” зэрэг хөөмийн урлагийн тухай олон тооны гарын авлага, сурах бичгүүд шинээр төрөн гарсаар байна.[28-34]

2001 онд монголын хөөмийчид нэгдэн "Монгол хөөмий" холбоо төрийн бус байгууллага байгуулсан нь одоогийн байдлаар Монголын 200 орчим, гадаадын 100 шахам хөөмийчийг нэгтгэн үйл ажиллагаа явуулж байна.

Хөөмийн урлагийн хөгжилд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 01 сарын 05-ны өдрийн 01 дугаар зарлиг гарсан нь томоохон түлхэц болсон байна. **Үүнд:**

1. Яруу өгүүлэхүйн эгшиглэнт урлаг хөөмийг өвлөн эзэмшиж, хөгжүүлэхийг монголын нийт ард, иргэдэд уриалсугай.
2. Монгол хөөмийг сургах, судлах, дэлгэрүүлэх зорилгоор өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулахыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжлийн багш, сурган хүмүүжүүлэгч, урлаг, соёлын зүтгэлтнүүдэд үүрэг болгосугай хэмээжээ.[35]

Үүний дараа Монгол улсын Засгийн газрын 2007 оны 159 дүгээр тогтоол гарч “Монгол хөөмий” хөтөлбөр батлагдсан нь Монгол хөөмийн урлагийг судалж сурталчлах, хадгалж хамгаалах, уламжлан хөгжүүлэх хөөмийн өвөрмөц дэг жаяг, арга маягийг сурч эзэмших, судалж хөгжүүлэх ажлыг соёл, урлагийн байгууллага, уран бүтээлч, ардын авъяастны дотор өрнүүлэн дэлгэрүүлэх улмаар түүний үндэсний болон олон улсын түвшинд эзлэх байр суурийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр болжээ.[36]

Өдгөө Монгол улс хөөмийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж хөгжмийн олон урсгалуудтай хоршин хэрэглэж байна. Үүнд Рок чиглэлээр: Алтан ураг, Жонон, Этник чиглэлээр Хөсөгтөн, “Халил”, “Домог” зэрэг хамтлагууд байхаас гадна 2016 онд байгуулагдсан “The Hu” хамтлаг нь дэлхийн хөгжмийн урсгалд “Хүннү Рок” хэмээх шинэ урсгалыг бий болгон дуулж хөөмийлөн уг хамтлагийн 2019 онд гаргасан “Гэрэгэ” цомог нь Монголоос анх удаа “Billboard”-ийг тэргүүлсэн нь өнөөгийн хөөмийн урлагийн хөгжил чухам ямар түвшинд хүрснийг илтгэх буй заа.[37]

Дүгнэлт: Хөөмийн урлагийг түүх, соёл урлаг, газар зүй, авиа зүйн талаас судалсан эрдэм шинжилгээний ажил цөөнгүй байгаа боловч анатоми бүтэц, үйлзүйтэй холбон судалсан эрдэм шинжилгээний ажил хомс байгаа нь цаашид энэ чиглэлээр хийгдэх судалгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Ном зүй:

1. *Behar A, Kumar M, Kunov H. A look at throat singing. Can Acoust - Acoust Can. 2001;29(1),*
2. *Finno-Ougrienne, A two-voiced song with no words, Journal de la société, №78, p. 43-56.1983, Suomen, On the application possibilities of overtone singing, Antropologi i Finland, 4, p. 249-255.*
3. *Энхжаргал Ш. “Монгол хөөмийн төрөл зүйлийн онцлог.” 2006.*
4. *https://ich.unesco.org/en/RL/mongolian-traditional-art-of-khoomei-00396*
5. *Mongol Music, The New Grove Dictionary of Music and Musicians, 12, New-York, Londres: Stanley Sadie, p. 482-485*
6. *Монголын хөгжмийн талаархи судалгааны тойм, Улаанбаатар: БСШУЯ, 2008 он 104-109 хуудас*
7. *Mark C Van Tongeren. Overtone singing. 2002. P-144, “Хөөмий урлаг бол төв азийн, нүүдэлчдийн соёл иргэншлүүдийн хоорондын соёлын харилцан ярианы бүтээл юм”. Улаанбаатар: Нүүдэлчдийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, х. 234-237.60*
8. *https://mongoltoli.mn/dictionary/detail/113204*
9. *Батцэнгэл нар (1980) "Уртын дуу, Хөөмий болон морин хуур." In Emmert and Minegishi 1980:52-3*
10. *Carole Pegg, Mongolian conceptualizations of overtone singing (хөөмii), British Journal of Ethnomusicology, a Dept of Social Anthropology, Cambridge University, Cambridge. 12:42, Published online: 31 May 2008*
11. *Б.Мөнхбадрал нар “Монгол хөөмэйн хөгжилд байгаль газар зүйн хүчин зүйлийн нөлөөлөл” 2012 03 21:”Дөрвөн бэрх” тоглолтон дээрх аман сурвалж 2000.04.07*
12. *П.Цэрэндорж, Ээвэн голын урсгал; Монголын Үндэсний олон нийтийн радиогийн архив. №32958, 25/06/1988; Үргэлжлэх хугацаа: 0’59 секунд,*
13. *Ээвэн голын урсгал; Монголын Үндэсний олон нийтийн радиогийн архив. Лимбэчин н.Түвшээ, №3474 1964 04 01; үргэлжлэх хугацаа: 1'06 секунд*
14. *Tserendavaa, truck driver and renowned overtone performer, interviewed in Cambridge during the "Music and Song of Mongolia" tour, 1988 08 05) (Мэндбаяр Ж. “Хөөмийн тархац бүс нутгийн онцлог.” 2009*
15. *Ж.Долгорсүрэн. Аман соёлын арга билгийн шүтэлцээ. УБ.,*

2000)

16. *Curtet Johanni [Кюртэ Жоанни], La transmission du höömij, un art du timbre vocal : ethnomusicologie et histoire du chant diphonique mongol, [Хоолойн өнгөний урлаг Монгол хөөмийн уламжлал, угсаатны хөгжим судлал, түүх] Хөгжим судлалын Докторын диссертаци, Рэннэ 2 Их Сургууль, 613 х. 2013.*
17. *Dargie, David (1991) "Umngqokolo: Xhosa overtone singing and the song Nondel'ekhaya." African Music 7.1:33-47.*
18. *https://www.youtube.com/watch?v=MYj-55T6Uzs&t=29s, "Umngqokolo: Xhosa overtone singing.*
19. *Cavanagh, Beverley. 1976. "Some Throat-Games of Netsilik Eskimo Women." Canadian Folk MusicJournal 4:43-47.*
20. *Sarashina, G., K. Tanimoto and Y. Masuda. 1965. Ainu Dento Hongaku (Traditional Ainu Music). Tokyo: N.H.K, 1983b. "The Rekkukara of the Ainu (Japan) and the Katajjaq of the Inuit (Canada): A Comparison." The World of Music/Le Monde de la musique 25(2):33-44.*
21. *(https://www.thecanadianencyclopedia.ca/en/article/inuit-vocal-games-emc*
22. *Matrenitsky, V., & Friedman, H. L. (2012). Matrenitsky, V., & Friedman, H. L. (2012). Transpersonal effects of exposure to shamanic use of Khoomei (Tuvan throat singing): Preliminary evaluations from training seminars [Research note]. International Journal of Transpersonal Studies, 31(2), 111–117.*
23. *Robert Oliver Beahrs, Post-Soviet Tuvan Throat-Singing (Xöömei) and the Circulation of Nomadic Sensibility, A dissertation for the degree of Doctor of Philosophy in Music in the Graduate Division of the University of California, Berkeley. 2014.*
24. *Mark C Van Tongeren. Overtone singing. 2002. P-144.*
25. *Edgerton, Michael, and Levin, Theodore. "The Throat Singers of Tuva." Scientific American, 1999, 80-87*
26. *Aksenov, A.N., "Tuvan Folk Music," Asian Folk Music 4, no. 2 (1973), pp. 7-18.*
27. *Б.Хас-Эрдэнэ. "Жаргалантын цуурай" хөөмийн гарын авлага.1983*
28. *Бат-Оюун Ч. "Монгол хөөмийн урлагийн зарим асуудал". 2002.*
29. *Энхжаргал Ш. "Монгол хөөмийн төрөл зүйлийн онцлог." 2006.*
30. *Мэндбаяр Ж. "Хөөмийн тархац бүс нутгийн онцлог." 2009.*
31. *Хэрлэн Л. Монгол Хөөмэйн Утга Холбогдол. Улаанбаатар; 2010.*
32. *Загд, Очир С. "Хөөмийчний уран чадварын зарим асуудал." 2012.*
33. *Цогтгэрэл Ц. Хөөмийлэх арга барилын асуудалд. 2013.*
34. *Одсүрэн Б. Монгол хөөмийн мэргэжлийн сургалтын арга барилын онцлог.*
35. *https://www.legalinfo.mn/law/details/755*
36. *(https://www.legalinfo.mn/annex/details/5804?lawid=5296*
37. *https://www.billboard.com/charts/world-albums*

The estimation of information about the origin and distribution of the Mongolian Khuumii

Rentsendorj.Ts[1], Ganchimeg.P[1], Byambasuren,L[2], Dagdanbazar.B[4], Enebish.S[3], Juramt.B[3], Nyamdorj.D[3]

[1]MNUMS-ENT department
[2]First national hospital-ENT
[3]MNUMS-Anatomy department
[4]Ach medical school
Email: rentsendorj@mnums.edu.mn, Tel: 976-11-321371

Background: Khoomii is Mongolian traditional art and a way of expressing the nation's sense in music and poetry. It is said that throat signing was invented long time ago but the precise time is not known. The throat singing is a Mongolian classic, professional and traditional folk art, which is a registered on the UNESCO in 2010.
Khoomii has been in the center of researchers attention and terminology of throat singing has been explained in many different ways. Some scholars state that khoomii is imitation of other sounds. Khoomii was developed in various ways in different parts of the country but origin of it stayed the same. It is the only traditional art that is sang by pair of sounds. There are different types of khoomii and Mongolian throat singing is divided into 4 man categories, Kharkhiraa, Isgeree, Narmai, and Shaahai. "Kharkhiraa" is similar to bass sound and it comes out of depth of a chest. "Isgeree" is a sound from an oral cavity. "Narmai" is a sound from nose. "Shaahai" is a sound when a singer squeezes his or her voice.
Mongolian Khoomii singers versify when they throat sing. Tuva throat singers do not versify but sometimes lulling when they sing. Khoomii can be sung in a modern music tune and also with the sound of all musical instruments. Mongolian throat singers have been the subjects of study for the world music critics and all the locals of Chandmani soum, Khovd province of Mongolia said to perform khoomii well.
The Mongolians have been developing this art, however Mongolian researchers and throat singers are in concern of mechanism of the throat singing in terms of the specific tone, and circumstances arise from the throat.
The tale of Khoomii: Once upon a time, a little orphan boy lived in a tall mountain's foot for 3 years. The mountain had lots of different sounds of eco and when the wind blows hard, a loud noise was created. As the little boy had no one but the nature to express himself he started mimicking the eco. When his voice reached other people in the area through wind, locals called it "Khoomii".
There are also isolated traditions elsewhere—for instance, among the Bashkirs of the republic of Bashkortostan in southwestern Russia and among Xhosa women and girls in south-central South Africa. A form of throat-singing is also used by Tibetan Buddhist monks of the Dge-lugs-pa sect during ritual performances and by the Inuit (Eskimos) of northern Canada during vocal games. None of these practices, however, involves the manipulation of harmonics that characterizes the Altai-Sayan traditions.
Conclusion: Although there are numerous researches on the history, art, geography and phonetic nature of the origin anddistribution of the Khuumii, there is a lack of scientific research on the anatomical structure and physiology, indicating the need to expand the scope of research in the future.

Key words: Mongolian Khuumii, origin, distribution, estimation, information